



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар A/212

Булган

Салбар зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн “б”, Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн 4.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 68 дугаар тогтоолын 1.6 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг Булган аймагт хэрэгжүүлэх салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Салбар зөвлөлийн дарга: - О.Гантулга /Аймгийн Засаг даргын орлогч/

Гишүүд: - Д.Буманбаяр /аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга/

- Д.Батцогт /аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга/

- Ч.Амгалан /ХХААГ-ын дарга/

- Ү.Бямбасүрэн /ГХБХБГ-ын дарга/

- Б.Батболд /МХГ-ын дарга/


- Н.Батжаргал /ХХҮГ-ын дарга/

- Ц.Бүрэнтуяа /СХЗХ-ийн дарга/

Нарийн бичгийн дарга: - Н.Пүрэвсайхан /ХХААГ-ын мэргэжилтэн/

2. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллаж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Салбар зөвлөл /О.Гантулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ



20190221